

ҮЙЛ АЖИЛЛАГААН

ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН
ТАЙЛАН

2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНИЙ
ТАЙЛАН

www.talkh-chikher.com

info@talkh-chiker.mn



АГУУЛГА



01

Компанийн ерөнхий тойм

- Компанийн тухай
- Эрхэм зорилго, Үнэт зүйлс
- 2022 оны зорилт
- Ажиллах хүчний нөөц

02

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Зах зээл өргөжүүлэлт, брэнд хөгжүүлэлт
- Үйлдвэрлэл /ISO 9001, ISO 45001 /

03

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Хураангуй тойм

04

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Хүний нөөцийн бодлого
- Нийгмийн хариуцлага, Ололт амжилт

“Талх чихэр”ХК

Г у р и л г у р и л а н б ү т э э г д э х ү ү н ү й л д в э р л э г ч

Эрүүл хүнс таны сонголт

“Талх Чихэр” ХК нь 1984 онд "Талх Чихрийн комбинат" нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж, 1999 онд 100% хувьчлагдаж, 4000 гаруй хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа Монголын топ 100 аж ахуй нэгжийн нэг.

Эрүүл хүнс Таны сонголт уриатай “Талх Чихэр” ХК өдгөө талх, талхан бүтээгдэхүүнийг 24 цаг тасралтгүй үйлдвэрлэх 6 шугам, нарийн боов үйлдвэрлэлийн 4 шугам, жигнэмэг, чихрийн шугам, бялуу, бэйкери төрлийн нандин бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Хотол” бялууны үйлдвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ хугацаанд бид АНУ, БНЧУ, БНСУ, Итали, Чех, Франц, Герман, Голланд, Испани, Финланд гэх мэт улстай гадаад харилцаагаа тэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн тоног төхөөрөмж, урсгал шугамыг салбартаа анх удаа нэвтрүүлэн, үйл ажиллагаагаа улам өргөжүүлсээр байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

“ТАЛХ ЧИХЭР” ХК



Бид олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэт технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хэрэглэгч харилцагчдынхаа сэтгэл ханамжинд үнэлэгдсэн хүнсний салбарын загвар компани байна.

АЛСЫН ХАРАА ҮНЭТ ЗҮЙЛС

“ТАЛХ ЧИХЭР” ХК

АЛСЫН ХАРАА

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Т** - Тэргүүн технологи
- А** - Аюулгүй бүтээгдэхүүн
- Ч** - Чадварлаг ажилтан
- И** - Итгэлцэл, түншлэл



2022 ОНЫ ЗОРИЛТ

“ТАЛХ ЧИХЭР” ХК



2

Компанийн хэмжээнд “Хотол үйлдвэр”, “Өвсоёл үйлдвэр”-ийг өргөжүүлэн ашиглалтанд оруулж “Хаан”, “Амтлаг”, “Онцгой” брэндийг хөгжүүлэн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

1

MNS ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлж үүсч болохуйц аюул, эрсдлийг үнэлж бууруулна



3

БНЧУ-н “J4” компани болон Итали улсын “SERI” компаниудтай хөрөнгө оруулалтын гэрээ хийж пормтой талх үйлдвэрлэлийн шугамын иж бүрэн шинэчлэлийг хийж бүтээмжийг нэмэгдүүлнэ.



4

Тодорхой нэр төрлийн Бялуу, Бэйкери, Чаналгын бүтээгдэхүүн дээр менежментийн бусад компанитай хамтран үйл ажиллагааг өргөжүүлэх, охин компани гаргах чиглэлээр холбогдох төслийн ажлуудыг хийнэ.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НӨӨЦ

“ТАЛХ ЧИХЭР” ХК



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЗЭХ ЗЭЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ, БРЭНДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж, шинэ хэрэглээ, соёл бий болж байгаа учраас бүтээгдэхүүний нэр төрөл нэмэх, бүтээгдэхүүний чанар стандартад анхаарах шаардлага байнга бий болдог. Энэ хүрээнд бид зах зээлээ өргөжүүлэн, хөгжүүлэх стратегийг баримтлан, хэрэглэгч, харилцагчидтайгаа эргэх холбоог сайжруулан, судалгааны ажлыг тогтмол хийсээр ирсэн.

2022 онд шинэ брэнд болон бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ зориулан үйлдвэрлэн, хүргэж эхэлсэн. Мөн маркетингийн арга хэрэгсэлээр дамжуулан хэрэглэгчдэд хэрэглээний шинэ соёл хэвшүүлэх, цаашлаад тухайн бүтээгдэхүүний онцлогт тохирсон маркетингийн стратегийг тодорхойлдог. 2022 онд Социал маркетингийн стратегийг баримлан үйл ажиллагаагаа өргөжүүлсээр байна.



Монгол Улсын ууган үйлдвэрүүдийн нэг болох “Талх Чихэр” ХК 2018 оноос хойш Дэлхийд алдартай Круассан буюу давхраат төрлийн бүтээгдэхүүний шинэ брэндийг зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байсан билээ. Ингэснээр Хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн олон улсын шинэ хэрэглээний соёлыг нэвтрүүлэхийн тулд

1. Техник, технологи
2. Бүтээгдэхүүний амт, төрөл
3. Чанар стандарт аюулгүй байдал
4. Боловсон хүчин

DÉLICE
PASTRY
Сэтгэл буцаам амт

гэсэн үндсэн хүчин зүйлд онцгойлон ач холбогдол өгч, 5 жилийн хугацаанд судалгаа туршилтын ажлыг шат дараатай хийж, сэтгэл булаам амт уриатай DELICE PASTRY брэндийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдийн гарт хүргэж эхлээд байна.



DÉLICE PASTRY НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ



Энэ хүрээнд бид Итали, БНЧУ, Герман, БНХАУ, Голланд улсын давхраат болон хөөмөл төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт судалгааны ажлыг дуусгаж, “Delice pastry” гэх шинэ брэндийг зах зээлд амжилттай нэвтрүүлж, албан ёсны нээлтийн арга хэмжээг амжилттай зохион байгуулж чадлаа. Уг арга хэмжээнд соёл, урлаг спортын шилдэг төлөөлөгчид, Монгол Улсад суугаа элчин сайдууд зэрэг олны танил эрхэмүүд хуран цуглаж, нэг өдрийг “Delice pastry” гэх шинэ брэндийн үйлдвэрлэлтэй танилцуулж үзүүлээ.



ХАРИЛЦАГЧИЙН ХҮЛЭЭН АВАЛТ

“ТАЛХ ЧИХЭР” ХК



Шинэхэн гарсан давхраат болон шанзтай хөөмөл бүтээгдэхүүний “Delice pastry” брэндийг эрхэм харилцагчиддаа таниулах зорилгоор үйлдвэртэй танилцах хүлээн авалтын арга хэмжээг бид амжилттай зохион байгуулсан. 1000 гаруй харилцагч оролцсон уг арга хэмжээний үеэр бид “Delice pastry” брэндийн бүтээгдэхүүний онцлог, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн үйлдвэрлэлийг бид хийж байгаа гэдгээ бодитоор харуулж чадсан.



Хотол

БЯЛУУНЫ ҮЙЛДВЭР 1984

“Талх Чихэр” ХК “Хотол” бялууг 1984 оноос хойш тасралтгүй үйлдвэрлэж, байгаа. Бялуу гэх амттан нь аливаа баяр ёслолын хамгийн гол чимэг байдаг. Тэр ч утгаараа “Хотол” бялууны үйлдвэр нь амтат бялууг баяр бүрийн гол амттан байлгах үүднээс тусгай загвар, чимэглэлтэйгээр Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын ISO22000:2005 стандартын дагуу үйлдвэрлэн хэрэглэгчдийнхээ гарт хүргэн ажиллаж байна.

Монголд бялуу, бялуун төрлийн бүтээгдэхүүний эрэлт хурдацтай өсөн нэмэгдэж байна. Тийм ч учраас нарийн мэдрэмж, технологи ажиллагаа, эрүүл ахуйн өндөр хяналт шаардсан бялуу, бэйкерийн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр онцгой ач холбогдол өгөн ажиллаж байна. Бид түүхий эд болон бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтийн үндсэн дээр өнөөдөр 30 гаруй нэр төрлийн бялуу 80 гаруй төрлийн бялуун төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

ХҮҮХДИЙН БАЯР

Хотол брэндийн хувьд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан нийслэлийн соёл урлагийн газартай хамтран “Үлгэрийн баатрууд амилсан нь” нэрийн дор баяраа тэмдэглэж байгаа бяцхан хүүхдүүддээ зориулан олон арга хэмжээ зохион байгуулсан.

Энэ хүрээндээ хүүхдүүдийн хайртай үлгэрийн баатруудыг бялуугаар урлан, амилуулж, Хотол бялууны үйлдвэрийн технологич, мэргэжилтэнүүд өөрсдийн ур чадвараа дахин нэг удаа батлан харуулж чадсан билээ.



ЦАГААН САР

Монголчуудын хувьд хаврын эхэнд сард тэмдэглэн өнгөрүүлдэг Сар шинийн баярт онцгойлон ач холбогдол өгдөг билээ. Тэр утгаараа гэр бүл, ах дүү амраг саднаараа уулзан, хуучлах энэ өдөрт зориулан баяр бүрийн хамгийн гол амттан байдаг баярын бялууг хэрэглэх соёлыг бид нэвтрүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж байна.



ВАЛЕНТИНА

Хосуудын хувьд хамгийн дурсамжтай нацийн өдөр нь мэдээжийн хэрэг Гэгээн валентины өдөр байдаг. Харин Хотол бялууны үйлдвэрийн хамт олон энэхүү эрхэм баярт зориулан тусгай загварын бялууг худалдаанд амжилттай гаргасан.

ЦЭРГИЙН БАЯР

Эх орны энхий манаанд тангараг өргөсөн эр цэргийн баярт зориулан бид тусгай загварын бялууг хийсэн. Ингэхдээ гэр бүл, үр хүүхдийнхээ төлөө бүхнийг зориулах хүчтэй аавууддаа чиглэсэн ажлуудыг бид хийсэн билээ.



МАРТ 8

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Талх Чихэр” ХК-ийн “Хотол” бялууны үйлдвэр компанийнхаа нийт бүсгүйчүүддээ зориулан 3м өндөр 120см диаметр бүхий ХОТОЛ БЯЛУУ хийж, гэнэтийн бэлэг барьлаа. 4 давхар уг бялууг 36 цагийн турш тасралтгүй хийсэн бөгөөд 24 сая төгрөгийн үнэлгээтэй уг бялууг хийхэд 45кг уусмал, 345кг кекс, 130кг сүүн крем, 9кг фондант, 52кг жимсний чанамал ашигласан байна.

Одоогоос 10 жилийн өмнө “Талх Чихэр” ХК 20 м урт бялуу хийж, Монголын хүүхэд багачууддаа бэлэг барьж байсан билээ. Харин өнөөдөр ийнхүү 500 эмэгтэй ажилчиддаа зориулан ийнхүү хагас тонн бүхий бялуу бүтээж, бэлэг барин баярлууллаа.

ХУРМЫН ЭКСПО

Монголын хуримын үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг хамгийн том албан ёсны “WEDDING EXPO-2022” хуримын үзэсгэлэнд “Талх Чихэр” ХК “Хотол” брэндийн бялуу болон “Түмэн насан” “Атар” хэвийн боовны брэндээр амжилттай оролцсон байна.



Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан бид Ковид-19 халдвар тархсантай холбоотойгоор 2 жилийн хугацаанд зогсоогоод байсан ажлуудаа дахин сэргээж эхэлсэн. Энэ хүрээнд:

- “Атар” хэвийн боовны нэрэмжит улс, аймгийн цолтой 2022 оны анхны хүчит бөхийн барилдаан
- “Хэвийн боовны үйлдвэрлэлийн нээлт”-ийн арга хэмжээг зохион байгуулсан.

Мөн бидний энэ жилийн хамгийн онцлох бүтээгдэхүүн нь залуу гэр бүлүүддээ зориулсан “Өв соёл” хэвийн боовыг дахин худалдаанд гаргаж, залуу гэр бүл бүр өв соёлоо дээдлэн тавгийн идээ засч, өвгөдөө хүндлэн золгох, амар мэнд мэдэх уламжлалаа хадгалж үлдэхийг уриалж ажилласан.



ҮЙЛДВЭРЛЭЛ

ISO 9001:2015

ISO 17025:2018

ISO 45001: 2018

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ISO 9001:2015 стандартын шинэчилсэн хувилбар руу шилжиж баталгаажуулах, түүнтэй холбоотой ажил төлөвлөлт хийж гүйцэтгэсэн. MNS ISO 17025:2018 стандартыг хими, микробиологийн лабораторын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн хүнсний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавин ажилладаг ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлыг төлөвлөн ажиллаж байна.

ISO 9001:2015 ДОТООД АУДИТ

“Талх Чихэр” ХК эрүүл, аюулгүй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор олон улсын “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 стандартын давтан баталгаажуулалтад амжилттай орж, гэрчилгээгээ гардан авсан




MNS ISO 17025:2018 ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОР

“Сорилт, шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих шаардлага MNS ISO 17025:2018” шинэчлэгдсэн стандартын шаардлага хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Сорилтын нийт үр дүнгээр бэлэн бүтээгдэхүүн 98,6%, түүхий эдийн 99,8% нь стандартын шаардлага хангасан. / чийглэг, тос, хүчиллэг/

Шар тос, шингэн өндөг зэрэг зарим шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэгчид мэдэгдэж буцаасан.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“ТАЛХ ЧИХЭР” ХК



Компани 2022 эхний хагас жилд **44,463,673** мянган төгрөгийн борлуулалт хийж, урьд оны энэ үеэс орлого **9,534,300** мянган төгрөгөөр буюу 35,1%-иар өссөн.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Ажиллагсдын хөгжил, ажлын идэвхийг нэмэгдүүлэх менежментийн тогтолцоо бүрдүүлэх, тогтвор сууршилт, үр бүтээлтэй ажиллагсдыг урамшуулах оновчтой, дүгнэхүйц, ил тод системийг бий болгох.



СУРГАЛТ ХӨГЖҮҮЛЭЛТ

Ажилчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг дотоод нөөц бололцоогоор тогтмол хийж хэрэгжүүлсэн. Сургалтанд нийт 220 гаруй ажилчид хамрагдсан

1. Галын аюулгүй байдал
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
3. ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандарт нэвтрүүлэх
4. ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо
5. Гадаад мэргэжилтэн болон зөвлөх инженерийн технологи болон тоног төхөөрөмжийн сургалт
6. Хувь хүний хөгжлийн сургалт
7. Шинэ ажилтны танилцуулах сургалт
8. Тусгай ур чадвар олгох сургалт
9. Шинэ бүтээгдэхүүний танилцуулга



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Ажиллагсдын хөгжил, ажлын идэвхийг нэмэгдүүлэх менежментийн тогтолцоо бүрдүүлэх, тогтвор сууршилт, үр бүтээлтэй ажиллагсдыг урамшуулах оновчтой, дүгнэхүйц, ил тод системийг бий болгох.



ШАГНАЛ УРАМШУУЛАЛ ТЭМЦЭЭН УРАЛДААН

Ажилчдаа тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс спортын тэмцээн, шагнал урамшуулал зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Мөн 48 ажлын байрыг шинээр бий болгосон.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Ажиллагсдын хөгжил, ажлын идэвхийг нэмэгдүүлэх менежментийн тогтолцоо бүрдүүлэх, тогтвор сууршилт, үр бүтээлтэй ажиллагсдыг урамшуулах оновчтой, дүгнэхүйц, ил тод системийг бий болгох.



ШАГНАЛ УРАМШУУЛАЛ ТЭМЦЭЭН УРАЛДААН

Олон жил ажилласан болон оны шилдэг ажилчдаа үнэлэн гадаад дотоодын аялалд жил бүр уламжлан болгон аялуулдаг уламжлалтай. Сүүлийн 2 жилийн хугацаанд ковидын цар тахлаас үүдэн уг ажлыг хэрэгжүүлж чадаагүй. Иймээс уг уламжлалт ажлыг дахин сэргээж, 2022 оны эхний хагас жилд 1-р ээлжийн ажилчдыг Турк улс дахь талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбартай танилцуулж, туршлага судлуулах аялалд явуулсан. Цаашид уг ажлыг тогтмол хэрэгжүүлж, 2-р хагас жилдээ багтаан 60 орчим шилдэг ажилчдаа дотоод гадаадын амралтад явуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй, мөн хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагаа үйл ажиллагаандаа тусган ажилдан нийгмийн хариуцлагатай компани юм.



БААТРУУДААРАА БАХАРХЪЯ

"Талх Чихэр" ХК жил бүрийн сар шинийн баярын өмнө Хөдөлмөрийн баатруудаараа бахархан хүндэтгэл үзүүлж, алдаршуулдаг уламжлалтай. Уг уламжлалын дагуу малчны хот, хөнгөн үйлдвэрийн цех, уул уурхай, урлаг, спорт гээд бүхий л салбараас өөрийн ажил хөдөлмөр хичээл зүтгэлээ төр засаг, түмэн олноороо үнэлүүлж, төрийн их хайр хишгийг хүртсэн эрхэмүүддээ хүндэтгэл үзүүлэх уг арга хэмжээг "БААТРУУДААРАА БАХАРХЪЯ" нэрийн дор 8 дахь жилдээ ийнхүү амжилттай зохион байгууллаа



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй, мөн хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагаа үйл ажиллагаандаа тусган ажилдан нийгмийн хариуцлагатай компани юм.



АЯЛАЛ-2022

Хөл хорионы хатуу дэглэм цуцлагдсантай холбогдуулан "Талх Чихэр" ХК өнгөрсөн 5 сард "Амглаг аялал" нэрийн хүрээнд Улаанбаатар хотын 10 жилийн сургууль, хамтран ажиллагч байгууллагын 1000 гаруй хүүхэд багачуудад үйлдвэрийнхээ үйл ажиллагааг танилцуулсан байна. Аялалд оролцсон хүүхэд бүртээ бид #Амглаг брэндийнхээ бүтээгдэхүүний дээжийг бэлэглэсэн билээ.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй, мөн хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагаа үйл ажиллагаандаа тусган ажилдан нийгмийн хариуцлагатай компани юм.



АЯЛАЛ-2022

“Талх Чихэр” ХК, Good Neighbors Mongolia ОУТББ-тай хамтран 18 нас хүрч, ирээдүйн амьдралдаа анхны алхамаа хийж байгаа хүүхдүүддээ зориулан мэргэжил сонголтод нөлөөлөх ажлын хүрээнд өөрсдийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулан, “Амтлаг” брэнд болон жигнэмэгийн үйлдвэрийн бүтээгдэхүүний дээжийг бэлэг болгон өгч, нэгэн өдрийг хөгжилтэй өнгөрүүллээ.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй, мөн хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагаа үйл ажиллагаандаа тусган ажилдан нийгмийн хариуцлагатай компани юм.



ХҮҮХДИЙН БАЯР

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 6 сарын 1-ний өдөр Жанжин Сүхбаатарын талбайд “Үлгэрийн баатрууд амилсан нь” нэрийн хүрээнд олон сонирхолтой хөтөлбөр бүхий арга хэмжээг Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн соёлын газартай хамтран зохион байгуулсан билээ. Энэ арга хэмжээний хүрээнд хүүхдүүдийн хайртай үлгэрийн баатрууд болох Пороро, Пони, Таёо, Халк, Хүн аалз, Элса, Энканто гэх мэт хүүхэлдэйн киноны баатруудыг Хотол бялууны үйлдвэрийн технологич, мэргэжилтэнүүд урлан, амилуулж, олон нийтэд танилцуулж, авъяас чадвараа өрсөлдөн түрүүлсэн багачууддаа бэлэглэж, урамшуулсан.





Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил цэцэглэлтэд оруулсан бидний хувь нэмрийг үнэлэн Засгийн газар, МҮХАҮТ хамтран “ТОП-100 аж ахуйн нэгж”-ийн 48-д жагсаж, өмнөх жилүүдийн амжилтаа дахин бататгаж чадлаа.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

